

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны 10 сарын 29 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ТАРИМАЛ УРГАМЛЫН ҮР, СОРТЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Таримал ургамлын үр, сортын тухай хуулийг дагаж мөрдхөөс өмнөх зургаан жилийн хугацаанд бүтээгдсэн модлог ургамал, дөрвөн жилийн хугацаанд бүтээгдсэн бусад ургамлыг бүтээгч нь хүсэлт гаргасан тохиолдолд энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хоёр жилийн дотор хянаж, сортын бүтээгчийн эрх олгон, хамгаалагдсан сортын бүртгэлд бүртгэнэ.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Таримал ургамлын үр, сортын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР